



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 30

Номгон

**Иргэний зөвлөлийг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.4-т заасныг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус “Иргэний зөвлөл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Иргэний зөвлөл нь бүрэн эрхийнхээ хүрээнд Цагдаагийн газрын төсвийн төсөл, зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонсох, цагдаагийн алба хаагчийн сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх ажилд хяналт тавих, тэдгээртэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд улирал бүр танилцуулж ажиллахыг “Иргэний зөвлөл”-ийн даргад үүрэг болгосугай.

3.Орон тооны бус “Иргэний зөвлөл”-ийн төсөв, гишүүдэд олгох урамшууллыг жил бүрийн төсвөөс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга/С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116035

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын  
18-ны өдрийн 30 дугаар тогтоолын хавсралт



ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Овог нэр
1	Долгорын Жаргалсайхан
2	Борын Өнөрбаяр
3	Жамцын Ихбаяр
4	Надмидын Батсайхан
5	Цэрэнноровын Нарантуяа

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_